

➤ **Санхүүжилт, хөрөнгө оруулалт болон байгууллагын тохижилт, үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийсэн ажил, үр дүнгийн талаар**

2017 оны эхний 11 сарын байдлаар улсын төсвийн санхүүжилт 99%, НДСангийн санхүүжилт 93,6%, өөрийн орлогын санхүүжилт 71,4%-ийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн тодотголоор 2017 оны 11 сард төсвийн орлогыг дараах байдлаар тодотгож өгсөн. Төрийн албан хаагчдад олгох 300,0 мянган төгрөгийн тэтгэмжид 94,2 сая төгрөг төсөвлөгдсөнөөр санхүүжилт 75,8 сая төгрөгөөр нэмэгдэж үндсэн төсвөөс 18,4 сая төгрөгөөр бууруулсан.

№		Төлөвлөгөө	Тодотгол	Тодотгосон дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сангаас	3 578 482,5	3 375 482.5	- 203 000,0
2	Улсын төсвөөс	1 165 746,3	1 444 589,8	278 843,5
3	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	135 157,8	135 157.8	0
<b>Нийт</b>		<b>4 879 386,6</b>	<b>4 955 230,1</b>	<b>75 843,5</b>

НДСангийн санхүүжилт 93.6%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь дараах үндэслэлтэй. Үүнд:

- Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн төв, нярайн эмгэгийн тасаг, гемодиализийн тасаг, цусны салбар банк, төвлөрсөн ариутгалын тасаг гэх мэт зөвхөн улсын төсвөөс санхүүжигдэх тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн хэдий ч орон тоо, үйл ажиллагааны зардал нь төсөвт тусгагдаагүй.
- Нийт санхүүжилт өмнөх оноос 3,89 хувиар өссөн хэдий ч ЭМДС-аас санхүүжих санхүүжилт 2016 оноос 11% буюу 628822,5 мян.төг-өөр өсч Улсын төсвийн санхүүжилт мөн хувиар буурсан учир ЭМД-ын сангаас санхүүжих санхүүжилтийг 200 000,0 мян.төг-өөр бууруулан Төсвийн санхүүжилтийг мөн хэмжээгээр өсгүүлэх тодотголыг хийлгэж ажиллалаа.
- Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг төсөвлөхдөө 27 түрээслэгчтэй байсан 2014 оны гүйцэтгэлээр төсөвлөж өгсөн тул биелэх боломжгүй болоод байна.
- 2016 оны эцэст 4722,7 мянган төгрөгийн түрээсийн болон актын төлбөрийн авлагатай байсан. Үүнийг шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад хандаад байна. 2017 онд нийт 8 түрээслэгч ажиллаж байгаа 11 сарын байдлаар 5 түрээслэгчийн 4144,4 мянган төгрөгийн түрээсийн авлагатай байна.

Одоогийн байдлаар байдлаар эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 56504,2 мянган төгрөгийн өр үүсээд байна. Энэ нь ЭМДСангийн санхүүжилт өссөнтэй холбоотой эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн тоо нэмэгдсэн, хими эмчилгээ шинээр хийгддэг болсон, диализын аппаратанд ордог өвчтөний тоо нэмэгдсэн ч эмийн төсөв нэмэгдээгүйтэй холбоотой.